# ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

## 1. АНХ БАТАЛСАН ТӨСӨВ

### 1.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

| ОН ДАМЖИН ХЭРЭГЖИЖ БАЙГАА | ШИНЭЭР ХЭРЭГЖИХ | НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ |
|---|---|---|
| 6 төсөл, арга хэмжээ | 30 төсөл, арга хэмжээ | 7,142.8 сая төгрөг |

**САНХҮҮЖИХ ДҮН**
**6,259.97**
сая төгрөг

### 1.2 ИХ ЗАСВАРЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

| ШИЛЖИХ ИХ ЗАСВАР | ШИНЭЭР ИХ ЗАСВАР | НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ |
|---|---|---|
| 4 төсөл, арга хэмжээ | 2 төсөл, арга хэмжээ | 990.7 сая төгрөг |

**САНХҮҮЖИХ ДҮН**
**685.7**
сая төгрөг

Булган аймгийн ИТХ-ын 2024 оны IV/26 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, 3 дугаар хавсралтаар их засварын төсөл, арга хэмжээг тус тус баталсан.

## 2. ТӨСӨВТ ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТ (Аймгийн ИТХ-ын 2025 оны X/74 дугаар тогтоол)

### 2.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ (Хавсралт 2)

| ӨМНӨХ ОНООС ШИЛЖИХ | ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ | ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ТЕХНИК ХЭРЭГСЭЛ |
|---|---|---|
| 6 төсөл, арга хэмжээ | 14 төсөл, арга хэмжээ | 13 төсөл, арга хэмжээ |
| 651.3 сая төгрөг | 2,783.4 сая төгрөг | 1,822.5 сая төгрөг |

**САНХҮҮЖИХ ДҮН**
**5,257.2**
сая төгрөг

### 2.2 ИХ ЗАСВАРЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ (Хавсралт 3)

| ӨМНӨХ ОНООС ШИЛЖИХ ИХ ЗАСВАР | ШИНЭЭР ИХ ЗАСВАР |
|---|---|
| 4 төсөл, арга хэмжээ | 2 төсөл, арга хэмжээ |
| 341.0 сая төгрөг | 669.3 сая төгрөг |

**САНХҮҮЖИХ ДҮН**
**1,010.3**
сая төгрөг

Аймгийн ИТХ-ын X/74 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалт болон их засварын төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулж баталсан байна.

## 3. НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН БҮТЭЦ (хувиар)




**БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ** — 57.96%
Барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээнд зориулах санхүүжилт

**ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ТЕХНИК ХЭРЭГСЭЛ** — 30.75%
Тоног төхөөрөмж, техник хэрэгслийн төсөл, арга хэмжээнд зориулах санхүүжилт

**ИХ ЗАСВАР** — 11.29%
Их засварын төсөл, арга хэмжээнд зориулах санхүүжилт

Орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах зорилгоор хөрөнгө оруулалт, их засвар болон тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг төлөвлөтгий, хэрэгжүүлж, үр дүнд хүрэхэд анхаарлаа.

# ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН

# 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 39 төсөл, арга хэмжээний **33.3** хувь нь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын тухайн жилийн үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцээгүй байна.

## ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨРӨЛӨӨР

/сая. төгрөгөөр/

| БАРИЛГА БАЙГУУЛАМЖ | АВТО ЗАМ, ДЭД БҮТЭЦ | ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ | ИХ ЗАСВАР |
|---|---|---|---|
| 2 төсөл | 1 төсөл | 9 төсөл | 1 төсөл |
| 425.0 сая төгрөг | 36.0 сая төгрөг | 1,026.82 сая төгрөг | 116.47 сая төгрөг |

**НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ**
1,764.29 сая төгрөг

**2025 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ДҮН**
1,764.29 сая төгрөг

## ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ (Нийт 13 төсөл, арга хэмжээ)

/сая. төгрөгөөр/

### БАРИЛГА БАЙГУУЛАМЖ – 2 төсөл

- Тагнуулын хэлтсийн алба хаагчдын орон сууцны төлбөр (2 ш орон сууц, 49.67 м², 58.87 м²) — 325.5
- Төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц худалдан авах (Баян-агт сум) — 99.5

**Нийт дүн** 425.0

### АВТО ЗАМ, ДЭД БҮТЭЦ – 1 төсөл

- Төрийн албан хаагчийн орон сууцны бариглын засварын цахилгаан хангамжийн нэмэлт ажил (Баяннуур сум) — 36.0

**Нийт дүн** 36.0

### ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ – 9 төсөл

- Аймгийн Засаг даргын тамгын газрын лифтний тоноглол, засвар — 70.0
- Лейд дэлгэц худалдаж авах (Баян-агт сум) — 39.5
- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны автомашин — 289.34
- Аймгийн Засаг даргын тамгын газрын албан хэрэгцээний автомашин — 200.00
- Сумын Засаг даргын тамгын газрын албан хэрэгцээний автомашин – 5 сум — 720.00
- Төрийн албаны Булган аймаг дахь салбар зөвлөлийн техник, тоног төхөөрөмж — 47.98

**Нийт дүн** 1,026.82

**СУМДЫН АВТОМАШИН – 5 төсөл**

- Гурванбулаг сум – 180.00
- Бугат сум – 180.00
- Тэшиг сум – 90.00
- Бүрэгхангай сум – 90.00
- Баян-агт сум – 180.00

**Нийт дүн: 720.00**

### ИХ ЗАСВАР – 1 төсөл

- Сумын ЗДТГ-ын бариглын засвар (Гурванбулаг сум) — 116.47

**Нийт дүн** 116.47

**ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙТ ДҮН**
1,764.29 сая төгрөг

Энэ нь цаашид хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь богино болон, урт хугацаанд үр дүн, үр өгөөж өгөх төсөл арга хэмжээ төлөвлөгдөхгүй байх **эрсдэлтэй** байгаад анхаарах шаардлагатай байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар "Түр амрах цэг шинээр байгуулах (Булган сум)" **68.5** сая төгрөгийн төсөл арга хэмжээг батласан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн **13** дугаар зүйлийн **13.3**-д

> "Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно"

**13.3.1-д**

"Хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах" гэсэн заалтыг зөрчиж байна.

Орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах зорилгоор хөрөнгө оруулалт, их засвар болон тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг төлөвлөтий, хэрэгжүүлж, үр дүнд хүрэхэд анхаараа.

# ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН

# 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Хэрэгжүүлэхээр батлагдсан 39 төсөл, арга хэмжээний **20.5** хувь нь буюу 8 нь эрэмбэлж үнэлээгүй **1,176.8** сая төгрөгийн төсөл, арга хэмжээ байна.

| НИЙТ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ | ЭРЭМБЭЛЖ ҮНЭЛЭЭГҮЙ | НИЙТИЙН ХУВЬ | НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ |
|---|---|---|---|
| 39 төсөл, арга хэмжээ | 8 төсөл, арга хэмжээ | 20.5% | 1,176.8 сая төгрөг |

## ЭРЭМБЭЛЖ ҮНЭЛЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ – 8

/сая. төгрөгөөр/

### АЛБАН ХЭРЭГЦЭЭНИЙ АВТОМАШИН

6 төсөл

- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны автомашин
- Аймгийн Засаг даргын тамгын газрын албан хэрэгцээний автомашин

Сумдын Засаг даргын тамгын газрын албан хэрэгцээний автомашин

- Гурванбулаг сум
- Бугат сум
- Тэшиг сум
- Бүрэгхангай сум

НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ **1,029.34** сая төгрөг

### ОРОН СУУЦ

1 төсөл

Төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц худалдан авах (Баян-агт сум)

НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ **99.5** сая төгрөг

### ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

1 төсөл

Төрийн албаны Булган аймаг дахь салбар зөвлөлийн техник, тоног төхөөрөмж

НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ **47.98** сая төгрөг

**ЭРЭМБЭЛЖ ҮНЭЛЭЭГҮЙ 8 ТӨСЛИЙН НИЙТ ДҮН 1,176.8** сая төгрөг

Орон нутгийн хэрэгцээ шаардлагыг эрэмбэлж тооцоо судалгаа хийгдээгүй, журмын шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ батлагдах нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулах **эрсдэлтэй** байна.

Иймд аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагч төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлэхдээ **"Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл арга хэмжээг үнэлж эрэмбэлэх үйл ажиллагаа журам"**-ын холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах зорилгоор хөрөнгө оруулалт, их засвар болон тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг төлөвлөтий, хэрэгжүүлж, үр дүнд хүрэхэд анхаараа.

# ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН

# 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

ТӨРИЙН АУДИТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламж барих, их засвар, тоног төхөөрөмж нийлүүлэх ажлуудаас:

| ЗУРАГ, ТӨСӨВГҮЙ | МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТГҮЙ | ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, АЖЛЫН ДААЛГАВАРГҮЙ | НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ |
|---|---|---|---|
| 1 төсөл, арга хэмжээ | 3 төсөл, арга хэмжээ | 1 төсөл, арга хэмжээ | 218.0 сая төгрөг |

## ДОРОХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ДЭЭРХ ШААРДЛАГЫГ ХАНГААГҮЙ ТӨЛӨВЛӨГДСӨН БАЙНА

| № | Төсөл, арга хэмжээний нэр, байршил | Шаардлага хангаагүй байдал | Төсөвт өртөг /сая. төгрөгөөр/ |
|---|---|---|---|
| 1 | Хилийн цэргийн 0286 дугаар ангийн ... дугаар заставын алба хаагчдын орон сууц барих (Тэшиг сум) | МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТГҮЙ | 50.0 |
| 2 | Түр амрах цэг шинээр байгуулах (Булган сум) | МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТГҮЙ | 68.5 |
| 3 | Төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц худалдан авах (Баян-агт сум) | ЗУРАГ, ТӨСӨВГҮЙ МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТГҮЙ | 99.5 |
| | НИЙТ ДҮН | | 218.0 |

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 -т заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвийг батлуулсан байх шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг ИТХ-аар баталдаг, батлагдсанаас хойш техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулдаг нийтлэг зөрчил давтагдан гарч байна.

**Иймд төсвийн ерөнхийлөн захирагч төсөл, арга хэмжээний санал, төлөвлөлтийг холбогдох журмын дагуу бүрдүүлж, техникийн болон хуулийн шаардлагыг хангаж ИТХ-д өргөн мэдүүлж, батлуулж ажиллах шаардлагатай байна.**

Орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах зорилгоор хөрөнгө оруулалт, их засвар болон тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг төлөвлөтий, хэрэгжүүлж, үр дүнд хүрэхэд анхаараа.

# БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

### Аудитын тайлан, дүнгээс:

Аймгийн хэмжээнд **234,9** тэрбум төгрөгийн **62** төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн Улсын төсөвт тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлснээс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар **батлагдсан жагсаалтад төсөл, арга хэмжээ тусгагдаагүй байна.**

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд **Улсын хэмжээнд болон бүсүүдэд хэрэгжүүлэх 7** төсөл, арга хэмжээнд Булган аймагт нийт **68,318.8** сая төгрөгийн нийт төсөвт өртөг, **16,180.7** сая төгрөгийг 2025 онд санхүүжүүлэх дүн тусгагдсан байна.

Дээрх төсөл арга хэмжээ нь **“Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”, “Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”**-тэй **нийцсэн байна.**

**Өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүдээс аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсэн 3 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд хэрэгжиж байна.**

Үүнд: **Булган аймгийн Гурванбулаг суманд 1.5 км, Сайхан суманд 1.7 км, Сэлэнгэ суманд 1.7 км хатуу хучилттай авто замуудыг**

**2024-2026** онд **5.2** тэрбум төгрөгийн өртгөөр гүйцэтгэж байна.

| ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ | УРТ, ХЭМЖЭЭ | ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА |
|---|---|---|
| Гурванбулаг сумын хатуу хучилттай авто зам | 1.5 км | 2024-2026 |
| Сайхан сумын хатуу хучилттай авто зам | 1.7 км | 2024-2026 |
| Сэлэнгэ сумын хатуу хучилттай авто зам | 1.7 км | 2024-2026 |

Сайхан сумын 1.7 км хатуу хучилттай авто замын мэдээллийн самбар хийгдээгүй байна.

Төрийн аудитад хууль дээдлэх, хараат бус, бие даасан байх, шударга ёсыг хангах, мэдээллээр бүрэн хангагдах, ил тод, бодитой байх

# БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Сэлэнгэ сумын Цахим сүлжээ сайжруулах гурвалсан үйлчилгээ нэвтрүүлэх **59.8** сая төгрөгийн ажлын хэрэгжилт хангалтгүй, тавигдах шаардлагад нийцээгүй байна.

**Аймгийн ОНТХО-ийн 39 төсөл, арга хэмжээ байгаагаас**

**31** төсөл, арга хэмжээний **5,508.9** сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагууд Орон нутгийн өмчийн газрын шийдвэрийн дагуу бүртгэлд тусгажээ.

**3** төсөл, арга хэмжээний **2,365.0** сая төгрөгийн өртөгтэй нь гэрээний хугацаа дуусаагүй.

**5** төсөл, арга хэмжээний **831.7** сая төгрөгийн нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас гарах данс бүртгэлд бүртгэх шийдвэрийг хүлээж байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хөрөнгийн бүртгэл, шийдвэр гаргалтад анхаарал хангалтгүй байгаагаас хөрөнгө оруулалтын үр дүн, үр ашиг буурах эрсдэлтэй байна.

Төрийн аудитад хууль дээдлэх, хараат бус, бие даасан байх, шударга ёсыг хангах, мэдээллээр бүрэн хангагдах, ил тод, бодитой байх

# ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН



## ЗӨВЛӨМЖ:

**Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.**

### АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА

- Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4215 -т заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвийг батлуулсан байх шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг хэлэлцүүлэн батлах.

### АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хууль, эрх зүйн холбогдох шаардлагад нийцүүлэн төлөвлөх, төлөвлөлтөд тавих хяналтыг сайжруулах.

### САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭСТ

- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо гэрээнд болон гүйцэтгэсэн ажил, хүлээж авахдаа хяналтыг хэрэгжүүлж санхүүжилтийг олгох.
- Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилт олгохдоо ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3-т заасан баримт бичгийн бүрдлийг цаасаар бүрэн бүрдүүлэх.



### АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАРТ

1. Төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон эд хөрөнгийн байнгын ашиглагчийг бүрэн тодорхойлж, бүртгэлд тусгах эрх зүйн шийдвэрийг бүрэн гаргах, ТАХ-г ашиглагч байгууллагын бүртгэлд тусгуулах.



Зөвлөмжийг хэрэгжүүлснээр төсөл, арга хэмжээний боломжит **эрсдэлийг бууруулах**, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, **үр өгөөжийг сайжруулахад** дэмжлэг үзүүлнэ.

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ | ХАРААТ БУС, БИЕ ДААСАН БАЙХ | ШУДАРГА ЁСЫГ ХАНГАХ | МЭДЭЭЛЛЭЭР БҮРЭН ХАНГАГДАХ | ИЛ ТОД, БОДИТОЙ БАЙХ | ОЛОН УЛСЫН НИЙТЛЭГ СТАНДАРТАД НИЙЦСЭН БАЙХ